



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/476

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэхь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Алтаргана наадмын үеэр ашиглагдах нийтийн эко жорлон барих ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан "Олзмандал" ХХК-тай 49 839 859 (дөчин есөн сая найман зуун гучин есөн мянга найман зуун тавин ес) төгрөгөөр гэрээ байгуулахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Олзмандал" ХХК-ийн захирал (Ц.Мөнхбаяр)-д үүрэг болгосугай.

4. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавихыг Булган сумын засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010614

Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 07-ны өдрийн
А/496 дугаар ахирамжийн хавсралт

| № | Нөхцөл шаардлага | Мөнгөн дүн | Хариуцах албан тушаалтан |
|---|--|--|---------------------------|
| 1 | Магадлашгүй ажил | 865 426 | Ү.Бямбасүрэн |
| 2 | Захиалагчийн техник хяналтын зардал | 865 426 | Ү.Бямбасүрэн |
| 3 | Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал | 423 713 | Ү.Бямбасүрэн |
| 4 | Алданги | Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна | Б.Бумцэнд |
| 5 | Баталгаат хугацаа | 3 жил | П.Нөхөрлөлбаяр |
| 6 | Чанарын баталгаа | Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана. | Б.Бумцэнд Ү.Бямбасүрэн |
| 7 | Ажил гүйцэтгэх хугацаа | Хуанлийн 16 хоног | Ү.Бямбасүрэн |